НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/620 Улаанбаатар хот

Хууль тогтоомж, эрх зүйн
чиглэлээр сургалт семинарыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагуудын удирдлага, ажилтнуудын дунд төрийн албан хаагчдын холбогдолтой хууль тогтоомж, эрх зүйн чиглэлээр сургалт семинарыг 2017 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Сургалт, семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, семинарыг байгуулахад шаардагдах 440.000 /Дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалт, семинарын бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /М.Цогзолмаа /-д үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны ....10 дугаар.....сарын 18-ны өдрийн
..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1116128787 ☎ 9077448

Хууль тогтоомж, эрх зүйн
чиглэлээр сургалт семинарыг зохион
байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын мөнгө: 2 хоног х 12 цаг х 20.000 төг	240.000
2.	Заал талбайн зардал	100.000
3.	Бичиг хэргийн зардал	100.000
ДҮН:		**440.000**

Боловсруулсан М.Цогзолмаа
Хянасан О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны ...10 дугаар...сарын 18-ны өдрийн
...11/62... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Сургалт, семинарт хичээл
заах багш нарын бүрэлдэхүүн

1.	Ж.Золжаргал	“Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн” ТББ
2.	Ө.Сэнгэдорж	МСК-ийн багш
3.	Э.Энхсайхан	ҮБТДС-ийн багш
4.	Х.Мөнхзул	“Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн” ТББ